Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Гарааны компани, оюуны өмч, технологи дамжуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, Баатар Туул

# 2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Шинжлэх ухааны нотолгоонд суурилсан дэвшилтэт технологи, инновацыг тэргүүлэх салбаруудад нутагшуулах замаар эдийн засгийн эрчимтэй хөгжлийг бий болгох бодлого, зохицуулалт хий | | | | | | | |
| 1 | Шинжлэх ухааны паркийн эрхзүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулна. | Боловсруулсан баримт бичгийн тоо | Судалгааны тайлан боловсруулсан. | Шинжлэх ухааны паркийн эрхзүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулсан байна. | Шинжлэх ухааны паркийн эрхзүйн байдлын тухай /анхдагч/ хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулахаар Хууль зүй дотоод хэргийн яаманд 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01/1003 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Хавсралт: 1 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 90% |
| 2 | Технологи дамжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | Технологи дамжуулах хөтөлбөрийг батлуулсан байна. | Технологи дамжуулах хөтөлбөр болон уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, хөтөлбөрийн зорилго, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх арга | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р | 90% |

159

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | замыг нарийвчлан тодорхойлсон. Уг хөтөлбөрийг таван жилийн хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж, энэ хугацаанд технологи дамжуулах үйл явцыг хурдасгах, дотоодын болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, инновацын экосистемийг бэхжүүлэх, хөрөнгө оруулалт татах боломжийг нэмэгдүүлэх зэрэг үндсэн чиглэлүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан болно. Хавсралт: 2 файл | сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 3 | Аж ахуй нэгж байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх эрх зүйн орчин бий болгох чиглэлээр шаардлагатай хууль, тогтоомжийн төсөл боловсруулна. | Боловсруулсан баримт бичгийн тоо | Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 22.2 | Хууль, тогтоомжийн төслийг боловсруулсан байна. | Аж ахуй нэгж байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх эрх зүйн орчин бий болгох чиглэлээр Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15, 22 дугаар зүйлд нэмэлт оруулах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. Үүнд: "15.9. Жилийн борлуулалтын орлого нь 2.5 тэрбум төгрөгөөс дээш аж ахуй нэгжийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө оруулалтын зардлыг 200 хувиар нэмэгдүүлж албан татвар ногдох орлогоос хасаж тооцно."; "22.16. 2.5 тэрбум | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төгрөгөөс доош борлуулалтын орлоготой аж ахуй нэгжийн судалгаа хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалтын зардлын 50 хувийг тухайн жилд оногдсон албан татвараас хасаж тооцно хэрэв татварын хөнгөлөлт нь тухайн жилийн татварын үүргээс их байвал илүү гарсан хэсгийг дараагийн 5 жилийн татвараас шилжүүлэн хасах эсвэл буцаан олгоно." гэж нэмэх саналыг тус тус хүргүүлсэн. Ингэснээр Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 22.2-т заасан "Засгийн газар хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх бөгөөд уг асуудлыг татварын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ" гэсэн заалт хэрэгжих боломж бүрдэнэ.<br>Хавсралт: 1 файл | | |
| 4 | Инновацын сан байгуулах хууль, тогтоомжийн төслийг боловсруулна. | Боловсруулсан баримт бичгийн тоо | ЗГҮАХ 3.3.7.6 | Инновацын сан байгуулах хууль, тогтоомжийн төслийг боловсруулсан байна. | Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд "Инновацын сангаас технологи, инновацын бүтээгдэхүүн болон инновацын дэд бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх" арга хэмжээг тусган, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжүүлэхээр хүрэх үр дүн, санхүүжилтын хамтаар батлуулсан. | сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 5 | Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журмыг шинэчлэн батлуулна. | Боловсруулсан баримт бичгийн тоо | ЗГ-ын 2015 оны “Журам батлах тухай” 267 дугаар тогтоол | Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журмын төслийг шинэчлэн боловсруулсан байна. | Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журмын төслийг шинэчлэн боловсруулсан.<br>Хавсралт: 1 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 6 | Монгол Улсын инновацын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангана. | Боловсруулсан баримт бичгийн тоо | Инновацын тухай хууль | Монгол Улсын инновацын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх төлөвлөгөөг боловсруулсан байна. | "Монгол Улсын судалгаа хөгжүүлэлт, инновацын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх судалгаа"-г ЭЗХЯ-ны урсгал төсвийн эх үүсвэрээр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусган, ажлын даалгаврыг батлуулсан. Судалгааг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж, шалгарсан байгууллагад гэрээ байгуулах тухай мэдэгдлийг хүргүүлсэн.<br>Хавсралт: 1 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 3.1. Шинжлэх ухаан, технологи, инновацын үйл ажиллагааны хэрэгжилт, зохицуулалтыг хანган ажиллана | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт 2025 оноос эхлэн хэрэгжүүлэх судалгаа, хөгжүүлэлтийн ажилд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаН ажиллана. | Сайдын тушаал, хэрэгжүүлж эхэлсэн төслийн тоо | Засгийн газрын 2022 оны 497 дугаар тогтоол | Сонгон шалгаруулах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, холбогдох шийдвэрийг баталгаажуулж, хэрэгжилтийг хангасан байна. | МУ-ын Тэргүүн Шадар сайд бөгөөд ЭЗХСайдын 2025 оны "Зардлын хуваарилалт батлах тухай" А/59 дүгээр тушаалаар Шинжлэх ухаан, технологийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний 2025 оны төсвийн зардлын хуваарилалтыг баталсан. тус зардлын хуваарилалтад Шинжлэх ухаан, технологийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд нийт 11.281 тэрбум төгрөг батлагдсанаас суурь судалгааны төсөлд 1.566 тэрбум төгрөг, улсын захиалгат төсөлд 369.5 сая төгрөг, цөм технологийн төсөлд 12.0 сая төгрөг, гадаадтай хамтарсан төсөлд 2.389 тэрбум төгрөг, үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөлд 1.1 тэрбум төгрөг, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөлд 567.5 сая төгрөгийг зарцуулахаар баталсан. 2025 оноос эхлэн хэрэгжих Суурь судалгааны болон Технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төслийн саналыг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 497 дугаар тогтоолоор баталсан "Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын дагуу 2025.01.31-2024.03.10- | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ны өдрүүдэд цахимаар (https://project.stf.gov.mn/) хүлээн авсан. ЗГ-ын 497 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу төслийн бүртгэл, баримт бичгийн бүрдэл, төслийн давхцал, удирдагчийн өртэй эсэхийг хянаж, шалгарсан төслийг мэргэжлийн шинжээчээр уншуулах, Мэргэжлийн хороогоор хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан. Мөн Технологийн туршилт, зүгшрүүлэлтийн 1 төслийн төсөвт өртөг 50.0 сая төгрөг байсныг 2025 оноос 70.0 сая төгрөг байхаар шийдвэрлэн, санхүүжилтыг төсөвт тусгасан. Хавсралт: 3 файл | | |
| 8 | Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт хэрэгжиж буй судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж үнэлэлт, дүгнэлт гаргана | Мониторингийн тайлан, дүгнэлт шийдвэрийн тоо | - | Төслийн хэрэгжилтийн явцын үнэлгээ дүгнэлт гарч, санхүүжилтийг шийдвэрлэн, судалгааны үр дүнг чанаржуулах, тасралтгүй үргэлжлэх зохицуулалтыг хангасан байна | - МУ-ын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны "Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх хугацаа сунгах тухай" А/24 дүгээр тушаалаар шинжлэх ухаан, технологийн суурь судалгааны төсөл-4, хятадтай хамтарсан төсөл-4, зорилтот төсөл-1-ийг 6-12 сарын хугацаатай сунгах шийдвэрийг баталгаажуулсан. - Хэрэгжиж дууссан Инновацын грант төслүүдийн тайлан, үр дүнг хэлэлцэн, хүлээн авах тухай | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хурлыг ШУТС-тай хамтран зохион байгуулсан.<br>Хавсралт: 1 файл | | |
| 9 | Шинжлэх ухаан, технологийн Үндэсний хороо болон салбарын харьяа байгууллагуудын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувь | 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө | Байгууллагуудын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан байна. | - ЭЗХЯ-ны харьяа Шинжлэх ухааны академи, Шинжлэх ухааны паркийн захиргаа, Шинжлэх ухаан, технологийн сангийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд холбогдох саналыг хүргүүлж ажилласан. - Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн дүрэм, бүтэц шинэчлэн батлагдахтай холбогдуулан дүрмийн төсөлд санал хүргүүлсэн. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 10 | Шинжлэх ухаан, технологи, инновацын үр дүнг орон нутагт түгээн дэлгэрүүлэх аяныг зохион байгуулна | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2024 онд 5 аймагт зохион байгуулсан. | Шинжлэх ухаан, технологи, инновацийн үр дүнг түгээн дэлгэрүүлэх аяныг 1 аймагт зохион байгуулсан байна. | Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 04-р сарын 30-ны өдрийн А/59 тоот тушаалаар сайдын багцаас шинжлэх ухаан, технологийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний 2025 оны төсвийн зардлын хуваарилалтыг баталсан. Тус зардлын хуваарилалтын 2.2 дахь заалтад шинжлэх ухаан, технологийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах үйл ажиллагааны зардалд 206,697,000.2 төгрөгийг тусган батлуулсан. Энэхүү хуваарилалт батлагдсан хугацаанаас шалтгаалан энэ оны орон нутагт шинжлэх ухаан, технологийг орон | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нутагт түгээн дэлгэрүүлэх аяныг II хагаст зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>Хавсралт: 1 файл | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субъект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөл, холбогдох бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад цахим, танхимаар хамрагдах | Яамны Мэдээллийн цаг, Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөл, холбогдох бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад цахим, танхимаар тогтмол хамрагдах | Мэдээллийн цаг, холбогдох сургалтад хамрагдсан тоо | Яамны Мэдээллийн цаг, Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөл, холбогдох бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад цахим, танхимаар хамрагдсан байна | - 2025.03-2025.06 сард Удирдлагын академийн "ТАХ-ийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт"-д хамрагдаж төгссөн. 2025.06.12-нд сертификатаа гардан авна.<br>- ТАЗ-ийн 30 жилийн ойд зориулан 3 үе шатаар зохион байгуулсан "ТӨРИЙН АЛБАНЫ РЕФОРМ-БИДНИЙ ШИЙДЭЛ" төрийн албан хаагчдын судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | уралдаанд "ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭЧЛЭЛД БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА, ИННОВАЦЫГ АШИГЛАХ НЬ" сэдэвт бүтээлээр яамны ахлах шинжээч С.Манлайдулам, шинжээч О.Золзаяа, ахлах мэргэжилтэн Л.Мөнхтуяа нарын хамтаар амжилттай оролцон, шилдэг 10-т шалгарсан. - Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яам болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)-аас хамтран зохион байгуулсан “Шинжлэх ухаан, технологи, инновацын паркийн бодлого, туршлага” сэдэвт үндэсний сургалт 2025 оны 4 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд хамрагдаж сертификат авсан.Тус сургалтад бодлого боловсруулагчид, шинжлэх ухаан, технологийн парк, бизнес инкубатор, хамтын оффис, технологи дамжуулах төвийн төлөөлөл, судлаачид, гарааны бизнес эрхлэгч нар болон олон улсын мэргэжлийн зөвлөхүүд, Шинжлэх ухааны паркийг амжилттай хөгжүүлж буй улс орны төлөөлөл зэрэг 40 гаруй төлөөлөл хамрагдсан. | | |

147

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн санаачилгаар орон даяар зохион байгуулж буй “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” сэдэвт Нийслэлийн бүсийн зөвлөгөөнд 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдөр хамрагдсан. Зөвлөгөөнд Нийслэлийн Засаг даргын тамгын газар, 9 дүүрэг болон яам, агентлаг, тэдгээрийн харьяа төрийн байгууллагын төлөөлөл 1200 албан хаагч оролцсон.<br>Хавсралт: 2 файл | | |

*Үнэлсэн:*

*Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга* ........................ */ Б.Урьболд /*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

ГУ32861 6606236 9022010236

2025.06.25

*(огноо)*

*Тайлагнасан:*

*Гарааны компани, оюуны өмч, технологи дамжуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн* .................... */ Б.Туул /*

48

(албан тушаал )

(гарын үсэг)

2025.06.25

(огноо)